



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 340

Улаанбаатар хот

Г Нийтэд санал болгон гаргаж буй Г
үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.9, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь

1. “Минжпроперти” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах 12 сарын хугацаатай, жилийн 17 хувийн хүүтэй, нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 100,000 ширхэг “Парк Таун Бонд” өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

2. “Минжпроперти” ХХК-ийн татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ болох 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөгийг бүрэн татан төвлөрүүлсэн тохиолдолд нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааг амжилттай болсонд тооцохоор тогтсугай.

3. Өрийн хэрэгслийг нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж үзэх хүртэл арилжаанаас олсон орлогыг тусгаарлахыг “Монголын үнэт цаасны бирж” ХК /Ж.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

4. Өрийн хэрэгслийн арилжааны тайланг анхдагч зах зээлийн арилжаа дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан тус Хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж, үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад заасны дагуу зарцуулахыг “Минжпроперти” ХХК /Т.Буянхишиг/-д үүрэг болгосугай.

5. Өрийн хэрэгслийн борлуулалт, үндсэн болон хүүгийн эргэн төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллахыг “Монголын үнэт цаасны бирж” ХК /Ж.Эрдэнэбат/, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/, Хяналт шалгалт, зохицуулалтын газар /Б.Долгорсүрэн/-т тус тус даалгасугай.

6. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж Хороо үзсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор өрийн хэрэгслийн барьцаа хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг “Монголын үнэт цаасны бирж” ХК /Ж.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

E:\ajil 2018\Blank\Togtool.doc


00736

7. Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөгдөх хугацааг үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссан өдрөөс тооцох ба үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд зохих төлбөрийг барьцаа хөрөнгөөр хангуулахыг “Минжпроперти” ХХК /Т.Буянхишиг/-д үүрэг болгосугай.

8. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “БДО Аудит” ХХК /Г.Баянмөнх/, “Өмгөөллийн Цогт энд Нандин” ХХН /Н.Нандинчимэг/, “Атен” ХХК /Б.Тэгшбаяр/-д тус тус анхааруулсугай.

9. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН